

## Англи хэлийг нэмэлт хэл эсвэл аялга болгон сурч буй сурагчдын тайлан

### Эцэг эх, асран хамгаалагчдад зориулсан мэдээлэл

Хүндэт эцэг эх, асран хамгаалагч танаа

Та хүүхдийнхээ сургуулиас сурагчийн сурлагын тайланг жилд хоёр удаа хүлээн авах болно. Уг тайлан нь таны хүүхэд хэрхэн ахиц дэвшил гаргаж, сургууль таны хүүхдийн сурах явцад хэрхэн дэмжлэг үзүүлж байгааг ойлгоход тусална. Таны хүүхдийн хичээл бүрт гаргаж буй ахиц дэвшлийг уг тайлан харуулах болно.

### Англи хэлийг нэмэлт хэл эсвэл аялга болгон үзэж буй сурагчийн тайлан (English as an additional language or dialect (EAL/D))

Хэрэв таны хүүхэд англи хэлийг нэмэлт хэл эсвэл аялга болгон сурч байгаа бол уг тайлангаар таны хүүхдийн сурлагын ахиц дэвшил, мөн түүнчлэн уг сурагчийн англи хэлний одоогийн түвшинг мэдээлэх болно. Суралцах явц нь анхан шатны, хөгжик буй, эсвэл суурь түвшин гэсэн үе шатуудтай байна. Эдгээр үе шатуудын талаарх мэдээллийг дараах хуудаснаас үзнэ үү.

### EAL/D хөтөлбөрт хамрагдсан сурагчдын тайлан

Хэрэв таны хүүхэд EAL/D хөтөлбөрт хамрагдаж байгаа бол EAL/D хөтөлбөрийн багшаас сурагчийн англи хэл сурч байгаа ахиц дэвшлийн талаарх нэмэлт тайланг хүлээн авна.

### Шинээр ирсэн EAL/D сурагчдын тайлан

Хэрэв таны хүүхэд EAL/D хөтөлбөрт хамрагдаж, Австралийн сургуульд дөрөв ба түүнээс бага улирал сурсан бол таны хүүхдийн тайландаангли хэлний сурлагын ахиц дэвшлийн талаарх мэдээлэл, мөн суралцаж буй бусад хичээлүүд дээр гаргаж буй ахиц дэвшлийн талаарх мэдээллийг аливаа дун дүгнэлтгүйгээр тайлбар маягаар гаргасан байх болно.

### Эрчимжүүлсэн Англи Хэлний Төвүүд эсвэл Эрчимжүүлсэн Англи Хэлний Ахлах сургуульд EAL/D хөтөлбөрийн дор шинээр суралцаж буй сурагчийн тайлан

Хэрэв таны хүүхэд Эрчимжүүлсэн Англи Хэлний Төв эсвэл Эрчимжүүлсэн Англи Хэлний Ахлах сургуульд элсэн орсон бол та сурагчийн англи хэл сурахдаа гаргаж буй ахиц дэвшлийн талаар тайлан авах болно. Үүнээс гадна уг тайлан тухайн сурагчийн ахлах сургуульд бэлтгэх явц болгон судалж буй бүх хичээл дээр гаргаж буй ахиц дэвшлийг харуулах болно.

## Англи хэлний ур чадварын үе шатууд

<b>Анхан шат</b>	Энэ шатанд сурагчид англи хэлийг сурч эхэлнэ. Тэд англи хэлнээс өөр нэг буюу хэд хэдэн хэлээр ярьж чаддаг бөгөөд төрөлх хэлээрээ тухайн насанд тохирсон бичгийн мэдлэгтэй болсон байна. Эдгээр сурагчид сургалтын хөтөлбөрийн дагуу англи хэлний энгийн дасгалуудыг гүйцэтгэж эхэлж байна.
<b>Шинээр суралцаж буй</b>	Уг шатанд суралцаж буй сурагчдын англи хэлний мэдлэг сайжирч байна. Эдгээр сурагчид англи хэлнээс гадна нэг болон түүнээс дээш хэлээр ярьж чаддаг бөгөөд тэдний англи хэлний бичгийн мэдлэг улам бүр нэмэгдсээр байна. Эдгээр сурагчад тохирох хэлний хичээлийг нь зааж мөн хичээлээ дуусгахад нь нэмэлт хугацаа, боломжоор хангахад ангидаа үндсэн хичээлд оролцож, суралцах чадвартай.
<b>Хөгжиж буй</b>	Уг шатанд сурагчид үндсэн англи хэлнээс гадна нэг буюу хэд хэдэн хэлээр ярьж, англи хэлний бичгийн мэдлэг нь улам хөгжинө. Эдгээр сурагчид хичээлдээ болон сургуулийн бусад үйл ажиллагаанд идэвхтэй оролцно. Мөн англи хэлний хичээл даалгавруудыг улам амжилттай гүйцэтгэх болно. Англи хэлний дүрмийг эзэмшиж үгийн сангаа баяжуулахад нь эдгээр сурагчийн төрөлх хэлний чадвар нь үнэтэй дэмжлэг байсаар байна.
<b>Суурь түвшин</b>	Уг шатанд байгаа сурагчид нэг буюу хэд хэдэн хэл, тэр дундаа англи хэлээр ярьж, англи хэлний бичгийн сайн мэдлэгтэй байх болно. Эдгээр сурагчид анти танхим болон сургуулийн үйл ажиллагаанд бие даан оролцдог бөгөөд англи хэлийг бусад хичээлд суралцах явцад амжилттай ашиглах чадварыг эзэмшинэ. Тэд тодорхой зорилго бүхий сэдвүүдээр яриаг ойлгож бичгээр боловсруулах чадварыг эзэмшсэн байх ч тэдэнд хичээллэхэд шаардлагатай академик хэл нэмэгдэхийн хэрээр EAL/D суралцагчдад чиглэсэн хэлний гүнзгийрүүлсэн сургалт, стратеги шаардлагатай хэвээр байна.

## Утсан Орчуулгын Үйлчилгээ

Хэрэв та нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл сургуультай холбогдоно уу. Сургуультай холбогдоход тань туслах орчуулагч хэрэгтэй бол Орчуулагчийн Үйлчилгээний (TIS) шугамын 131 450 дугаарт залгаж, өөрийн хэлээр орчуулагч авна уу. Орчуулагч нь сургууль руу залгаж, утсан дээр байж ярианд туслах болно. Энэ үйлчилгээ үнэ төлбөргүй.